


**ХЭНТИЙ ОРОН СУУЦ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН  
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

8.6.5	төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг	“Хэнтий орон сууц” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /хаяг-Хэнтий хэрлэн сум 3-р баг баян-эрдэнэ,баатаруудын гудамж-01 01тоот/
8.6.5	дүрэм	Хавсралтаар
8.6.5	үйл ажиллагааны чиглэл	Аймгийн хэмжээнд иргэдийг орон сууцжуулах талаар баримтлаж байгаа бодлого, стратеги төлөвлөлтийг хэрэгжүүлэх,бага дунд орлоготой иргэд, төрийн албан хаагчдыг хямд үнэтэй,чанартай орон сууцаар хангах,орон сууцны нөхцлийг сайжруулах,түрээсийн орон сууцанд хамруулах,хөнгөлөлтийн бодлого чиг үүргийг хэрэгжүүлэх
8.6.5	эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан	байхгүй
8.6.5	нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг	байхгүй
8.6.6	төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн,	Нийт 9
8.6.6	тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх-/ийн нэр, өөрийн нэр	Дарга- Лхам Батсайхан -Аймгийн Засаг даргын орлогч  Нарийн бичгийн дарга – Гүрцэдэн Ариунхүү – АЗДТГазрын төсвийн зарлага хариуцсан мэргэжилтэн  Гишүүн –Сүрэн Нямдаваа –АЗДТГ СТСХ-ийн дарга  Гишүүн- Энхболд Мөнх-Эрдэнэ – ХОХБТХэлтэсийн дарга  Гишүүн –Баатарцогт Дарханбаатар – ХЭЗХэлтэсийн дарга

		Гишүүн- Сэдэд Бат-Эрдэнэ – АИТХурлын нарийн бичгийн дарга Гишүүн- Ганболд Лхагвахатан-ОНӨГазрын дарга ТББайгууллагын төлөөлөл гишүүн- Наваандоной Ганболд- тэтгэвэрт Иргэний төлөөлөл гишүүн-Оюун Од-Эрдэнэ- МХС ТӨК-ний Хэнтий аймгийн газрын дарга
8.6.6	авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн	ТУЗ гишүүд цалин урамшуулал авдаггүй
8.6.6	албаны цахим шуудангийн хаяг	khentiikhos@gmail.com
8.6.6	тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам,	байхгүй
8.6.6	сонгон шалгаруулах ажиллагааны тов	байхгүй
8.6.6	сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл	байхгүй
8.6.8	төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл	байхгүй

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 25 дугаар сарын 31-ны  
өдрийн 25 дугаар тоогоолын 01-р хавсралт

"ХЭНТИЙ ОРОН СУУЦ" ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХҮЙН  
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ



### Нэг. Нийтлэг үндэслэл

1. "Хэнтий орон сууц" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь Хэнтий аймгийн хүн амыг хямд үнэтэй, чанартай орон сууцаар хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, төрөөс зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах хөнгөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэхчиг үүрэг бүхий өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах бие даасан аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар мөн.

1.2. "Хэнтий орон сууц" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь /цаашид "Үйлдвэрийн газар" гэх/ Монгол Улсын Үндсэн хууль, Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль, Орон сууцны тухай хууль, Газрын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухайхууль болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, аймгийн ИТХ-ын тогтоол, Тэргүүлэгчдийн хурлын тогтоол, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан захирамж, болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаага эрхэлнэ.

1.3. Энэхүү дүрмийн зорилго нь үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тогтоох, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, хяналт, үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, үүргийг тодорхойлох, хөрөнгийн хөдөлгөөн, бүртгэлтүүнийг өөрчлөн зохион байгуулах, бүртгүүлэх эзэртэй холбогдсон харилцааг хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино.

### Хоёр. Үйлдвэрийн газрын нэр, хаяг, тэмдэг

- 2.1. Үйлдвэрийн газрын оноосон бүтэн нэр нь "Хэнтий орон сууц" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар.
- 2.2. Үйлдвэрийн газрын байршил нь түүний удирдлагын байрлаж буй хаягаар тодорхойлогдох бөгөөд хаягийн өөрчлөлийг Үйлдвэрийн газрын захирал тухай бүр улсын бүртгэлд хуулийн хугацаанд бүртгүүлнэ.
- 2.3. Үйлдвэрийн газар нь албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэгтэй байна.
- 2.4. Бэлгэдэл, тэмдгийн загварыг захирал баталж, Оюуны өмчийн газарт бүртгүүлсэн байх бөгөөд түүний хэрэглэх эрхийг "газар" эдэлнэ.
- 2.5. Тэмдэг нь албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулах ба үйлдвэрийн газрын захирлаас итгэмжлэн хариуцуулсан

этгээд, тэмдгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцна.

**Гурав. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны чиглэл, хугацаа**

- 3.1. Үйлдвэрийн газар нь Хэнтий аймгийн хэмжээндиргэдийг орон сууцжуулах талаар баримталж байгаа бодлого, стратеги төлөвлөлтийг хэрэгжүүлэх, бага дунд орлоготой иргэд, төрийн албан хаагчдыг хямд үнэтэй, чанартайорон сууцаар хангах, орон сууцны нөхцөлийг сайжруулах, түрээсийн орон сууцанд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах, хөнгөлөлтийн бодлого, чиг үүргийг хэрэгжүүлнэ.
  - 3.1.1. Гадаад, дотоодын хөрөнгийн зах эзэлээс санхүүжилтийн эх үүсвэр татах ажлыг олон хэлбэрээр зохион байгуулах замаар хөрөнгийн тогтвортой сан бүрдүүлж, барилгын хөрөнгө оруулалт, зээл санхүүжилтийг цогцоор нь шийдвэрлэх;
  - 3.1.2. Аймгийн нутаг дэвсгэрт орон сууц бариулах ажлыг зохион байгуулах;
  - 3.1.3. Өөрийн байгууллагын санхүү, хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх;
  - 3.1.4. Үйлдвэрийн газрын барьсан болон захиалан бариулсан орон сууцны хотхон, хорооллын барилга, байгууламж, талбайг түрээслүүлэх, худалдан борлуулах, гэрээний биелэлтийг хангуулах;
  - 3.1.5. Тусгай зөвшөөрөлтэйгадаад, дотоодын компани, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран орон сууц, үл хедлөх хөрөнгийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;
  - 3.1.6. Залуу гэр бүл болон төрийн албан хаагчдад чиглэсэн орон сууцжуулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, урт хугацааны, хямд түрээсийн орон сууцны менежментийг хэрэгжүүлэх;
  - 3.1.7. Аймгийн төв болон сумдад хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хамтран ажиллах гэрээгээр хэрэгжүүлэх;
  - 3.1.8. Хувийн хэвшлийн хөрөнгөөр барьсан орон сууцны тодорхой хэсгийг худалдан авах;
- 3.2. Үйлдвэрийн газар нь үндсэн зорилтод нийцсэн хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагааг эрхэлж болно.
- 3.3. Үйлдвэрийн газар нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа эрхлэхээр бол холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч, улсын бүртгэлд бүртгүүлсний дараа тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.
- 3.4. Хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр өөрчлөн байгуулах, хувьчлах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд үйлдвэрийн газар нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

**Дөрөв. Үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, үүрэг ТБОНӨТ.х /16.1/**

- 4.1. Үйлдвэрийн газар нь өөрийн эзэмшиж байгаа эд хөрөнгийн хэмжээгээр



дараах эрх, үүрэгтэй байна.

4.1.1. Өөрийн өмчлөлийн үл хөдлөх хөрөнгө болон хөрөнгө эзэмших эрхийн гэрчилгээгээр олгогдсон актив хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах;

4.1.2. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ өөрөө бие даан борлуулах;

4.1.3. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас хуульд заасан татвар хураамжийг төлж үлдэх хэсгээстодорхой хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсний дараа өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх, байгууллага хөгжүүлэх, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, байгууллагын үндсэн зорилтод нийцсэн төсөл, хөтөлбөрт хөрөнгө оруулалт хийх, зохих журмын дагуу захиран зарцуулах;

4.1.4. Үйлдвэрийн газар нь үндсан хөрөнгийг орон нутгийн өмчийн газрын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр үндсэн хөрөнгийг олж авах, акталж данснаас хасах, худалдан борлуулах, устгах, шилжүүлэх;

4.2. Үйлдвэрийн газар нь өөрийн өмчийн хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг өмчлөг болон орон нутгийн өмчийн газар хариуцаж ажиллана.

#### Тав.Үйлдвэрийн газрын Төлөөлөн удирдах зөвлөл

5.1. Үйлдвэрийн газар нь "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хууль, болон холбогдох бусад хууль, дүрэм, журамд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-тэй байна. ТУЗ-ыг аймгийн ИТХТ-ийн хуралдаанаас энхүү дүрмийн хавсралтаар батална.

5.2. Үйлдвэрийн газрын бүтэц зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг ТУЗ хэлэлцэн батална.

5.3. ТУЗ-ийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

5.3.1. Үйлдвэрийн газрын жилийн төсөв, бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэж батлах;

5.3.2. Нэмэлтээр хөрөнгө оруулалт хийх тохиолдолд хэлэлцэн батлах;

5.3.3. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны тайланг дүгнэх/хагас, бүтэн жилээр/;

5.3.4. Үйлдвэрийн газрын шинээр худалдаж авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудлыг хэлэлцэж, дүгнэлт гаргах;

5.3.5. Үйлдвэрийн газрын аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох, үйлдвэрийн газрын тайлан тэнцэлд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах;

5.4. ТУЗ-ийн хурлыг зарлан хуралдааныг явуулахдаа Орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хуулийг дагаж мөрдөнө.

5.5. ТУЗ-ийн гишүүд нь гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн нарийн бичгийн



даргаар дамжуулан өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бичиг баримт, тайлан мэдээлэл зэргийг амаар болон бичгээр авна.

#### **Зургаа.Үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлага**

- 6.1. Үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлага нь үйлдвэрийн газрын дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Гүйцэтгэх удирдлага нь үйлдвэрийн газрын захирал байна.
- 6.2. Захирлыг аймгийн Засаг дарга ТУЗ-тэй зөвшилцөж томилж, чөлөөлнө. Үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг захирал удирдана.
- 6.3. Захирал нь Монгол Улсын "Териин болон орон нутгийн өмчийн тухай" хуульд заасан шалгуурыг хангасан байна.
- 6.4. Захирал нь аймгийн Засаг дарга, ТУЗ-аас олгосон эрх хэмжээний хүрээнд үйлдвэрийн газрыг төлөөлнө хэлцэл хийх, гэрээ байгуулах зэрэгээр үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах ба дараах эрх үүрэгтэй байна.
  - 6.4.1. Холбогдох хууль тогтоомжийн хүрээндүйлдвэрийн газрын дүрэм, зорилтын санал, бизнес төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
  - 6.4.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, удирдаж буй газрын хэвийн үйл ажиллагааг хангасны үндсэн дээр санхүү, төлбөрийн чадвар, нэр хундийг бүх талаар дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;
  - 6.4.3. Үйлдвэрийн газрын эрх ашгийг дээдэлж, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан ажиллах;
  - 6.4.4. Ажил үүргээ гүйцэтгэх явцад олж авсан үйл ажиллагааны болон бизнесийн нууцыг чанд хадгалах, хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;
  - 6.4.5. ТУЗ-өөс баталсан удирдлагын бүтэц, зохион байгуулалтын хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтийг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гарээ байгуулах, цалингийн хэмжээ, урамшууллын журмыг тогтоох, хууль тогтоомжийн хүрээнд ажлаас чөлөөлэх;
  - 6.4.6. Закирлын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлага, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин хөлс, урамшуулал зэрэг асуудлыг хөдөлмөрийн гэрээнд тусгах;
  - 6.4.7. Хууль тогтоомж болон гэрээгээр олгосон бусад эрх үүргийг хэрэгжүүлэх;
  - 6.4.8. Захирал өөрийн эрх, үүргийг аймгийн Засаг даргатай зөвшилцөн итгэмжлэлийн үндсэн дээр холбогдох албан тушаалтанд түр шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлэх үндэслэл болохгүй;
  - 6.4.9. Захирал нь өөрийн эрх хэмжээний хүрээнд хууль, дүрэм, журмын

дагуу тушаал гаргана;

- 6.5. Захирал орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээдийг төлөөлөн удирдах зөвлөлд орох, тэдгээрийн захиргаанд буюу олон нийтийн болон шашны байгууллага, сангийн удирдах ажлыг хавсрان гүйцэтгэхийг хориглоно.

**Долоо. Үйлдвэрийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт**

- 7.1. Үйлдвэрийн газрын үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ хяналт тавина.
- 7.2. Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт гаргуулна.
- 7.3. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалт, ашиглалтын үйл ажиллагаанд Орон нутгийн өмчийн газар хяналт тавьж ажиллана.
- 7.4. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг Захирал хариуцан хэрэгжүүлнэ.

**Найм. Үйлдвэрийн газрын санхүүжилт, бүртгэл, тайлан ТБОНӨТ.т /24.1/**

- 8.1. Үйлдвэрийнгазар нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, Олон Улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.
- 8.2. Үйлдвэрийнгазрын санхүүгийн тайлангийн үнэн зөвийг захирал, нягтлан бодогч нар хариуцна.
- 8.3. Үйлдвэрийн газрын нягтлан бодогч нь мэргэжлийн байх бөгөөд мэргэжлээрээз-аас доошгүй жил ажилласан байна.
- 8.4. Үйлдвэрийнгазрын санхүүгийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, мен оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.
- 8.5. Үйлдвэрийн газрын тухайн жилийн орлого нь санхүүгийн бүсвэрээс бүрдэнэ. Үүнд:
  - 8.5.1. Ажил, үйлчилгээнээс олсон бүх орлого;
  - 8.5.2. Байгууллагатай хамтарч ажиллах гэрээний дагуу олох үйлчилгээний орлого;
  - 8.5.3. Төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааны дагуу татах гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын эх үүсвэр;
  - 8.5.4. Хандивлагдсан хандив, зээл, тусламж;
  - 8.5.5. Банкан дахь дансны үлдэгдлийн болон хадгаламжийн хүү;
  - 8.5.6. Хууль тогтоомжоор зөвшөөрсөн бусад эх үүсвэр;



- 8.6. Үйлдвэрийн газар нь тухайн жилийн үйл ажиллагаа, хөрөнгө санхүү, үр дүнгийн талаар тодорхой тусгасан тайланг ТУЗ, аймгийн Засаг даргад болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнана.

**Ес.Үйлдвэрийн газрын бичиг баримтыг хадгалах**

- 9.1. Үйлдвэрийн газар нь дараах бичиг баримтыг хадгална. Үүнд:

9.1.1. Газрын дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлттэй холбогдох газруудын шийдвэр, тогтоол, улсын бүртгэлийн гэрчилгээ болон бусад гэрчилгээ сертификатууд;

9.1.2. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримтууд, түүнд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримтууд;

9.1.3. Үйлдвэрлэл, технологи, норм нормативууд түүнтэй холбогдох дүрэм, журам, зааврууд, бусад бичиг баримтууд;

9.1.4. Хурлын тэмдэглэл, шийдвэр, захирлын гаргасан тушаал, шийдвэрүүд;

9.1.5. Бусад ач холбогдол бүхий баримт бичгүүд;

- 9.2. Дээрх бичиг баримтыг зохих журмын дагуу холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах, архивт шилжүүлэх зэрэг ажлыг захирлын туслах, бичиг хэргийн ажилтан эрхлэн гүйцэтгэнэ.

**Арав. Газрыг татан буулгах**

- 10.1. Үйлдвэрийн газрыг аймгийн Засаг даргын саналаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчид үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.

**Арван нэг. Хариуцлага**

- 11.1. Монгол Улсын хууль тогтоомж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захираамжийн биелэлтийг хэрэгжүүлэх явцад буруу шийдвэр гаргаж бусдад хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон бол холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

- 11.2. Захирал нь эрх мэдлээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглаж байгууллагад хохирол учруулсан бол уг хохирлыг байгууллагын захирал өөрийн хувийн емчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна.

- 11.3. Захирал нь Монгол Улсын хууль тогтоомж, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчвэл хуульд заасан хариуцлага хүлээнэ.

**Арван хоёр.Бусад**

- 12.1. Энэхүү дүрэмд тусгагдаагүй бусад асуудлыг Төрийн болон орон нутгийн емчийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.

- 12.2. Үйлдвэрийн газрын энэхүү дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс

эхлэн хүчин төгөлдөр болно.

- 12.3. Үйлдвэрийн газрын дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлтийг хууль тогтоомжид заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.



ооо

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгдчийн 2021 оны 23 дугаар сарын 27-ны  
өдрийн 23 дугаар тоогтоолын 02-р хавсралт

"ХЭНТИЙ ОРОН СУУЦ" ОНӨААТҮГ-ЫН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга мэргэжилтэн	СТСХ-ийн орлогын
Гишүүд	1. АИТХНБ-ийн дарга 2. ХЭЗХ-ийн дарга 3. СТСХ-ийн дарга 4. ХОХБТХ-ийн дарга 5. ОНӨГ-ын дарга 6. ТББ-ын төлөөлөл 7. Иргэний төлөөлөл